

БАТЛАВ.	БАТЛАВ.	БАТЛАВ.
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД	САНГИЙН САЙД	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
Г.ДАМДИННЯМ	З.МЭНДСАЙХАН	Г.ТЭМҮҮЛЭН

2026 оны ... дүгээр сарын ... - ний өдөр

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж, мөн 16 дугаар зүйлийн 2 дахь заалтад Монгол Улсын иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлаас олон улсын худалдааны нөхцөл байдал, гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан дотоодын зах зээл дээр стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, даван туулах арга хэмжээг тодорхойлох, холбогдох шийдвэрийг шуурхай гаргахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр “Стратегийн ач холбогдол бүхий бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийг дэмжих хууль”-ийг 2030 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд дагаж мөрдөхөөр баталсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор² баталсан “Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021–2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2 дахь зорилтод “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно”, 4.2.16 дахь зорилтод “Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтцийн сүлжээ, нефть-химийн үйлдвэр барьж байгуулна” гэж урт хугацааны бодлогын зорилт дэвшүүлсэн.

¹ Төрийн мэдээлэл: 1992 он, №01

² Төрийн мэдээлэл: 2020 он, №25

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор³ Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.3.1.6 дах заалтад “Дорноговь аймагт дотоодын түүхий эдэд түшиглэсэн газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулж, олон улсын стандартын шаардлага хангасан авто бензин, түлшний тодорхой хувийг дотоодоосоо хангах нөхцлийг бүрдүүлнэ.” гэж, мөн хөтөлбөрийн 3.3.1.9 дэх заалтад “Газрын тосны бүтээгдэхүүний 3-6 сарын хэрэглээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулна” гэж тусгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 70 дахь заалтад дээрх хөгжлийн бодлогуудыг хэрэгжүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, салбарын бусад хууль тогтоомжтой нийцүүлэх, нэр томьёоны тодорхойлолтыг сайжруулах, шинэ төрлийн түлш, шатахуун, чанарын хяналт тавихтай холбогдсон харилцааг тусгаж, эрх зүйн орчныг сайжруулна” гэж заасан нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

1.2. Практик шаардлага:

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль нь 2005 онд анх батлагдсанаас хойш 20 гаруй жилийн хугацаанд хэрэгжиж байгаа бөгөөд энэ хугацаанд 9 удаа нэмэлт, өөрчлөлт орсон ч нийгэм, эдийн засгийн хөгжил, Ойрхи дорнод болон ОХУ, Украйны дайны нөлөөгөөр газрын тосны бүтээгдэхүүний импортод үүсч буй бэрхшээл, эрэлтээс үүдэлтэй шатахууны нөөц, хангамжийн системд үүссэн асуудлыг шийдвэрлэхэд дараах практик шаардлагууд байна. Үүнд:

1.2.1. Шатахууны нөөц, хангамжийн тасалдалд хариу арга хэмжээний механизмтай холбоотой асуудал:

Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээгээ 100 хувь импортоор хангадаг бөгөөд импортын ойролцоогоор 95 хувийг ОХУ, үлдсэн хувийг БНХАУ эзэлдэг. Хэрэглээ 2023 онд 2.4 сая тонн, 2024 онд 2,808,129 тонн байсан бол 2025 онд 2,973,015 тонн болж өмнөх оноос 5.8 хувиар өссөн байна.

2026 оны 08 дугаар сарын байдлаар газрын тосны бүтээгдэхүүний агуулах шинээр барих, өргөтгөх, шинэчлэх төслүүдэд хөнгөлөлттэй зээлийн санхүүжилт олгож, улсын хэмжээнд хадгалах багтаамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, нийт 18 аж ахуйн нэгжийн 22 агуулахын төсөлтэй хариуцлагын гэрээ байгуулж, нийт 248,200 м³ багтаамж бүхий агуулах шинээр барих, өргөтгөх ажил хэрэгжиж байгаа бөгөөд төслүүдийн барилга угсралтын гүйцэтгэл 5–85 хувьтай хэрэгжиж байгаа болно.

Гэвч одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн агуулахыг ямар зарчим, шалгуураар төлөвлөх, хаана, ямар хүчин чадлаар байгуулах, улсын болон компанийн нөөцийн агуулахыг хэрхэн ангилах, тэдгээрийн өмчлөл, эзэмшил, ашиглалт, санхүүжилт, нөөц бүрдүүлэлт, сэлгэлт, хадгалалт, зарцуулалт, нөхөн бүрдүүлэх практик харилцааг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүй байна. Үүнээс шалтгаалан эдгээр бий болж буй мега дэд бүтцийг хангамжийн гэнэтийн тасалдал үүссэн

³ Төрийн мэдээлэл: 2024 он, №35

хямралын үед төр, хувийн хэвшлийн уян хатан түншлэлээр шуурхай дайчлан ашиглах, нэгдсэн төлөвлөлтөөр удирдахад хэрэгжилтийн шатанд эрх зүйн хүндрэл, зөрчил үүсэхээр байна.

Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тасалдал, хомсдол үүссэн үед улсын болон компанийн нөөцийг зах зээлд нийлүүлэх нөхцөл, дараалал, шийдвэр гаргах эрх бүхий байгууллагын бүрэн эрх, нөөц эзэмшигчийн эрх, үүрэг, ашигласан нөөцийг нөхөн бүрдүүлэх хугацаа, түүнтэй холбоотой зардал, хариуцлагыг бүхэлд нь Засгийн газрын баталсан холбогдох Захиргааны хэм хэмжээний актын хүрээнд зохицуулж байна.

Иймд цаашид шинээр баригдаж, өргөтгөгдөж байгаа агуулахуудыг зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн арилжааны үйл ажиллагаанд ашиглахаас гадна шатахууны хангамжийн тогтвортой байдлыг хангах, компанийн болон улсын нөөц бүрдүүлэх бодлоготой уялдуулах эрх зүйн шаардлага үүсэж байна. Үүний зэрэгцээ улсын нөөцийн агуулахыг бүсчилсэн байдлаар төлөвлөх, импортын боомт, төмөр зам, авто зам, хүн амын төвлөрөл, хэрэглээний хэмжээ, алслагдсан бүс нутгийн хангамжийн онцлогийг харгалзан байршил, хүчин чадлыг тогтоох шаардлагтай байна.

Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тасалдлын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөө, түүнийг батлах, шинэчлэх, олон нийтэд мэдээлэх зохицуулалт байхгүй, нөөц ашиглах дэс дараалал тодорхой бус, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бүрэн хангахад эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

1.2.2. Чанар, стандарт, лабораторийн нэгдсэн тогтолцоотой холбоотой асуудал:

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7.1.1-т зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олон улсын стандартад нийцсэн чанартай газрын тосны бүтээгдэхүүн импортлох үүрэгтэй гэж заасан. Импортоор оруулж буй газрын тосны бүтээгдэхүүний стандарт нь үндэсний стандартаас зөрөх тохиолдол багагүй үүсдэг байна. Иймд Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны бүтээгдэхүүн тус бүрт үндэсний стандарт болон техникийн зохицуулалтыг боловсруулж, үйлдвэрлэх, импортоор оруулах, тээвэрлэх, хадгалах, түгээх, борлуулах, хяналт тавихад нэг мөр мөрдүүлэх нь чухал байна.

Хуулийн хэрэгжилтийн үнэлгээгээр газрын тосны бүтээгдэхүүний салбарт үйл ажиллагаа явуулж буй 636 тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн мэдээллийн нэгдсэн цахим систем дутмаг, хяналтын механизмын хүчин чадал хангалтгүй байгаагаас шалтгаалан газрын тосны бүтээгдэхүүний чанар, стандартын хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх практик шаардлага байна.

Өнгөрсөн хугацаанд чанарын шаардлага хангаагүй газрын тосны бүтээгдэхүүнийг худалдаалах явдлыг хязгаарлах, хуурамч шатахуун үйлдвэрлэхэд ашиглагдаж болзошгүй нефтийн бүтээгдэхүүн, түүхий эдэд онцгой албан татвар тогтоох замаар эдийн засгийн аргаар зохицуулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Гэвч практик амьдрал дээр зөвхөн татварын болон захиргааны хяналтын арга механизмаар шатахууны чанарыг бүрэн баталгаажуулах боломжгүй бөгөөд салбарын нэгдсэн цахим систем, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дотоод хяналтын үүрэг, хариуцлагыг хуулиар нарийвчлан зохицуулаагүй байна. Уг нөхцөл байдал нь шударга бизнес эрхлэгчдийг хамгаалах эрх зүйн баталгааг бэхжүүлэх,

чанарын хяналтын тогтолцоог цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагаанд эрх зүйн зохицуулалтыг улам нарийвчлах хэрэгцээг үүсгэж байна.

Бүх төрлийн шатахууны чанарын хяналтыг бүх үе шатанд тасралтгүй хийдэг болох үүргийг хуульд тусгах, бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах лабораторийн нэгдсэн тогтолцоог үүсгэх, шинжилгээний нэгдсэн аргачлалыг баталж нэвтрүүлэх, лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар холбогдох эрх, үүргийг хуульд тодорхой тусгах практик шаардлага байна.

Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын сорьц авах, хадгалах, тээвэрлэх, шинжлэх, давтан шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг бүртгэх, мэдээлэл солилцох асуудлын салбар дундын зохицуулалтыг бий болгох, эдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих цахим системийн нэгдсэн зохицуулалтыг бий болгох, хуульд тусгах шаардлагатай юм.

1.2.3. Газрын тосны бүтээгдэхүүний нөөц, хангамжийн цахим мэдээллийн тогтолцоо болон шатахуун хадгалах савны автомат хэмжилттэй холбоотой асуудал:

Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 05 тоот “Засгийн газрын шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” шийдвэрийн 1.5 дахь хэсэгт зааснаар “Стратегийн ач холбогдол бүхий бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтэд зохиомол хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор шатахуун импортлогч аж ахуйн нэгжүүдийн агуулахын үлдэгдлийг хянах системийг яаралтай ашиглалтад оруулах”-ыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд үүрэг болгосон байна.

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, уул уурхай, газар тариалан, төмөр зам, агаарын тээврийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар болон бусад байгууллагын харьяанд нийт 123 газрын тосны бүтээгдэхүүний агуулахын 1,137 шатахуун хадгалах сав, 1,560 орчим шатахуун түгээх станцын 5,420 орчим шатахуун хадгалах сав ашиглагдаж байна.

Эдгээр савны багтаамж, хийц, ашиглалтад орсон хугацаа, техникийн нөхцөл, хадгалж буй бүтээгдэхүүний төрөл, хэмжилтийн төхөөрөмж болон автоматжуулалтын түвшин харилцан адилгүй бөгөөд шатахуун хадгалах савны ердөө 20 орчим хувь нь автомат түвшин хэмжигч төхөөрөмжөөр тоноглогдсон, үлдэх дийлэнх саванд бүтээгдэхүүний түвшнийг гар аргаар хэмжиж, мэдээллийг гараар бүртгэн тайлагнаж байна.

Гэвч практик амьдрал дээр хадгалах савны үлдэгдэл, хэмжилтийн нэгдсэн цахим системийг нэвтрүүлэх эрх зүйн суурь шаардлага, автоматжуулалтыг үе шаттай хэрэгжүүлэх урамшуулал, дэмжлэгийн уян хатан механизм салбарын хуульд тодорхой бус байна. Үүнээс шалтгаалан, шатахууны бодит үлдэгдлийг шуурхай, үнэн зөв мэдээлэх нэгдсэн цахим системийг бүрдүүлэх, аж ахуйн нэгжүүдийн тайлагналын үйл ажиллагаа цахимжуулж, бичиг хэргийн ачааллыг технологийн шийдлээр хөнгөвчлөх эрх зүйн зохицуулалтыг улам нарийвчлах шаардлагатай байна.

Ашиглаж байгаа бүх саванд автомат түвшин хэмжигч болон мэдээлэл дамжуулах төхөөрөмжийг нэгэн зэрэг суурилуулах нь их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддагаас гадна сав бүрийн хийц, ашиглалтын нөхцөл, хадгалж байгаа

бүтээгдэхүүний шинж чанарт тохирсон инженерийн судалгаа, зураг төсөл, техникийн шийдлийг харгалзан үзэх, мөн тоног төхөөрөмж суурилуулах үеийн аюулгүй байдал, техникийн шаардлагыг хангах, угсралт, туршилт, тохируулга хийх, хэмжил зүйн баталгаажуулалт хийлгэх зэрэг ажиллагаа шаардагдана.

Газрын тосны бүтээгдэхүүний нөөц, хангамжийн цахим мэдээллийн системийн тогтолцооны үндсэн зорилго нь газрын тосны бүтээгдэхүүний импорт, шилжүүлэлт, хадгалалт, ачилт, түгээлт, борлуулалт, савны үлдэгдэл болон бүтээгдэхүүний чанар, хөдөлгөөний мэдээллийг улсын хэмжээнд цахим хэлбэрээр цуглуулах, нэгтгэн боловсруулах юм. Энэхүү системийг бүрдүүлснээр шатахууны бодит нөөц, бүтээгдэхүүний төрөл, байршил, хадгалалтын хүчин чадал, орлого, зарлага, хэрэглээ, чанар болон хангамжийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг шуурхай авах, хангамжийн эрсдэлийг урьдчилан үнэлэх, зохиомол хомсдол үүсэхээс сэргийлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангах, шаардлагатай үед төрөөс шуурхай зохицуулалт хийх мэдээллийн үндэс бүрдэнэ.

Цахим мэдээллийн тогтолцоог бодитой, үр дүнтэй ажиллуулахын тулд газрын тосны бүтээгдэхүүний агуулах болон шатахуун түгээх станцын шатахуун хадгалах савны бүтээгдэхүүний түвшин, температур, түвшин, орлого, зарлага болон үлдэгдлийн мэдээллийг хэмжилтийн төхөөрөмжөөс хүний оролцоогүйгээр цахим хэлбэрээр хүлээн авах техникийн боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Иймд шатахуун хадгалах саванд автомат түвшин хэмжигч, шаардлагатай мэдрэгч, мэдээлэл дамжуулах төхөөрөмж болон хяналт, удирдлагын программ хангамж зэрэг орчин үеийн хэмжилт, автоматжуулалтын технологийг суурилуулж, цахим мэдээллийн тогтолцоотой холбох хэрэгцээ үүсэж байгаа болно.

Иймд газрын тосны бүтээгдэхүүний чанар, нөөц, хангамжийн цахим мэдээллийн системийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн үндсийг бий болгох шаардлагатай байна.

1.2.4. Салбар дундын зохицуулалт болон хууль хоорондын уялдаа холбоог хангах талаарх асуудал:

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад шатдаг хийн хэрэглээ жилээс жилд өсөн нэмэгдэж, ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар шингэрүүлсэн нефтийн хий (LPG), шахсан байгалийн хий (CNG), шингэрүүлсэн байгалийн хий (LNG) зэрэг хийн түлшний хэрэглээ өргөжин хөгжиж байна. Үүнтэй холбоотойгоор хийн түлшний импорт, хадгалалт, тээвэрлэлт, түгээлт, ашиглалт, аюулгүй ажиллагаа, техникийн шаардлага, хяналтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Өнөөгийн байдлаар шатдаг хийтэй холбоотой харилцааг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль болон түүнийг дагалдан гарсан зарим дүрэм, журмаар хэсэгчлэн зохицуулж байгаа боловч хийн аюулгүй ажиллагаа, техник, технологийн шаардлага, ашиглалтын үеийн эрсдэлийн удирдлага, хяналт, мэргэжлийн байгууллагын эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоог цогцоор нь зохицуулсан бие даасан хууль, тогтоомж байхгүй байна. Иймээс шатдаг хийн салбарын техник, технологийн онцлог, аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага бий болсон.

Иймд цаашид шатдаг хийтэй холбоотой аюулгүй ажиллагаа, хадгалалт, тээвэрлэлт, түгээлт, ашиглалт, техникийн шаардлагад хяналт тавихтай холбоотой зохицуулалтыг сайжруулах практик шаардлага байна.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд шатдаг хийн аюулгүй ажиллагаатай холбоотой харилцааг техникийн зохицуулалтаар тогтоож хангах, түүнийг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн дагуу баталж, мөрдүүлэх эрх зүйн зохицуулалт шаардлагатай.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 6.1.3-т газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр, агуулах, түгээх станц барьж байгуулах, шинэчлэх зураг төсөлд техник, технологийн талаар дүгнэлт гаргах, 6.1.4-т газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход мэргэжлийн дүгнэлт гаргах, 6.1.5-д газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд ажиллах бүрэн эрхийг тус тус олгосон.

Барилгын тухай хуульд барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх, барилга байгууламжийг ашиглалтад оруулах, барилгын норм, нормативын баримт бичгийг боловсруулахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулсан бөгөөд уг хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тогтоолоор "Барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн ерөнхий тогтолцоо", "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм", "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм" зэрэг эрх зүйн актуудыг батлан мөрдүүлж байна. Эдгээр эрх зүйн актуудаар барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах үйл ажиллагааг зургийн даалгавар боловсруулах, загвар зураг (эскиз), эх загвар зураг боловсруулах, зураг төслийг зөвшилцөх, магадлал хийх, барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүртэлх үе шат бүрээр нарийвчлан зохицуулж, тухайн ажиллагаанд оролцох байгууллага, эрх бүхий этгээдийн чиг үүргийг тодорхойлсон байдаг.

Барилгын тухай хуулиар тодорхойлсон барилга байгууламжийн ангилалд газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийг тодорхойлон тусгах, онцгой аюултай техник, технологийн өндөр эрсдэлтэй барилга байгууламжийн онцлогийг харгалзан салбарын төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын хянах, зөвшилцөх эрхийг Барилгын тухай хууль, тогтоомжид тусган зохицуулах шаардлагатай байна.

Иймд энэхүү асуудлын салбар дундын зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байна.

1.2.5. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт болон хуулийн бусад зохицуулалтын харилцааны асуудал:

Хүчин төгөлдөр үйлчилж буй газрын тосны бүтээгдэхүүний хуулийн нэр томьёоны тодорхойлолтод одоо байгаа нэр томьёонуудыг тодорхой болгон найруулах шаардлагатай байна. Тухайлбал “газрын тосны бүтээгдэхүүн”, “түгээх станц”, “компанийн нөөц”, “газрын тосны боловсруулах үйлдвэр”, “завсрын бүтээгдэхүүн” зэрэг болно. Мөн газрын тосны бүтээгдэхүүний хуулийн нэр томьёоны тодорхойлолтод шинээр “шатдаг хий” “газрын тосны бүтээгдэхүүний нөөц”, “газрын

тосны бүтээгдэхүүний хэрэлэгчийн нөөц”, “газрын тосны бүтээгдэхүүний чанар”, “газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт”, “хангамжийн тасалдал, хомсдол” гэсэн нэр томъёонуудыг тусган зохицуулах шаардлага тулгарч байна.

Салбарын суурь харилцааг зохицуулж буй Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг 2005 онд баталснаас хойш Зөвшөөрлийн тухай хууль (2022), Хэмжил зүйн тухай хууль (2019), Галын аюулгүй байдлын тухай хууль (2015), Барилгын тухай хууль (2016), Өрсөлдөөний тухай хууль (2010), Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль (2017) зэрэг хуулиуд шинэчлэгдсэн тул тэдгээртэй уялдуулан Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хийдэл, давхардлыг арилгах хэрэгцээ практикт тулгарсан.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулах бөгөөд дараах асуудлыг тусгана:

- нэр томъёо, зохицуулалтын хамрах хүрээ, хуулийн зорилт болон үндсэн ойлголтыг шинэчлэн тодорхойлох;

- бүх төрлийн шатахууны импорт, худалдаа, хадгалалт, тээвэрлэлт, чанарын хяналт, улсын нөөц болон компанийн нөөц бүрдүүлэлттэй холбоотой газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг боловсронгуй болгох;

- газрын тосны бүтээгдэхүүний үнийн огцом хэлбэлзэл, хангамжийн тасалдал, хомсдолын үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөө батлах, шатахууны заавал байлгах нөөц, түүнийг хадгалах агуулах, шилжүүлэн ачих болон тээвэрлэлтийн дэд бүтцийн хүчин чадлыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан үе шаттайгаар шийдвэрлэх эрхийг Засгийн газарт нээж өгөх;

- газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоо, лабораторийн үйл ажиллагаа, техникийн шаардлага, норм, дүрэм, журам, стандарт боловсруулах, мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгох;

- газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, агуулах, түгээх станц, техник, технологийн байгууламжид тавигдах шаардлага, мэргэжлийн байгууллагын техник, технологийн дүгнэлттэй холбоотой зохицуулалтыг шинэчлэн тогтоох;

- газрын тосны бүтээгдэхүүний барилга байгууламжийн зураг төсөл хянах, ашиглалтад оруулах ажиллагаанд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын оролцоог хангах;

- газрын тосны бүтээгдэхүүний нөөц, хангамжийн цахим мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглахтай холбоотой зохицуулалтыг бий болгох;

- цахим мэдээллийн систем болон автомат түвшин хэмжигч суурилуулах ажлыг үе шаттай, эрсдэлд суурилсан байдлаар хэрэгжүүлэх зохицуулалтыг бий болгох;

- шатдаг хийн импорт, үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, цэнэглэлт, түгээлт, ашиглалтын аюулгүй ажиллагааны заавал дагаж мөрдөх үндсэн шаардлагыг техникийн зохицуулалтаар тогтооно. Техникийн зохицуулалтыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу баталж, мөрдүүлэхээр тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар салбарын хөгжлийг дэмжих, хангамжийн тогтвортой байдлыг хангах болон төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх хүрээнд дараах бодит үр дүнд хүрнэ:

1. Хуулийн зорилт болон нэр томъёоны тодорхойлолт болон үндсэн ойлголтуудыг салбарын өнөөгийн хөгжил, олон улсын техникийн стандартад нийцүүлэн шинэчлэн тогтоосноор нэр томъёоны зөрүү, хууль хэрэглээний эрсдэл арилж, хуулийн үйлчлэх хүрээ тодорхой болно.
2. Газрын тосны бүтээгдэхүүний үнийн илтэд үндэслэлгүй өсөлт, хангамжийн тасалдал, хомсдолын үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлах эрх зүйн үндэслэл бүрдэнэ. Түүнчлэн шатахууны заавал байлгах нөөц болон түүнийг хадгалах агуулах, шилжүүлэн ачих, тээвэрлэлтийн дэд бүтцийн хүчин чадлыг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх төр, хувийн хэвшлийн чиг үүрэг, хариуцлагын зааг ялгааг тодорхойлон тогтооно.
3. Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр, агуулах, шатахуун түгээх станц (ШТС) болон холбогдох техник, технологийн байгууламжид тавигдах аюулгүй ажиллагаа, байгаль орчин, техникийн шаардлагуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн тогтооно. Энэ нь онцгой эрсдэлтэй объект дах аваар ослын эрсдэлийг бууруулж, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажлын байрны аюулгүй байдлыг хангах эрх зүйн суурь баталгааг бүрдүүлнэ.
4. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагаас гаргах техник, технологийн дүгнэлт олгох үндэслэл, шалгуур, журам тодорхой болно. Барилга байгууламжийн зураг төсөл, магадлал хийх, ашиглалтад оруулах шатанд салбарын мэргэжлийн байгууллагын оролцоо Барилгын тухай хууль тогтоомжтой уялдан хангагдсанаар техникийн дутуу шийдэлтэй, онцгой эрсдэлтэй байгууламж ашиглалтад орохоос урьдчилан сэргийлнэ.
5. Чанарын хяналтын нэгдсэн тогтолцоо бүрдэж, лабораториудын шинжилгээний аргачлал жигдэрснээр стандартын шаардлага хангаагүй шатахуун худалдаалах зөрчил хязгаарлагдана. Ингэснээр чанаргүй шатахуунаас шалтгаалж иргэдийн тээврийн хэрэгсэл эвдрэх, санхүүгийн хохирол амсах эрсдэл арилж, автотээврийн хэрэгслээс гарах хорт утааны ялгаралт багасан агаар, орчны бохирдлыг бууруулахад бодит ахиц гарна.
6. Нэгдсэн цахим мэдээллийн системийн бодит ажиллагаа хангагдана. Улсын хэмжээнд байгаа бүх шатахуун хадгалах саванд автомат түвшин хэмжигч болон мэдээлэл дамжуулах төхөөрөмжийг үе шаттай суурилуулснаар савны үлдэгдэл, орлого, зарлагын механик оролцоогүйгээр бодит цагийн горимд

хянах нөхцөл бүрдэнэ. Энэ нь салбарын хэмжээнд зохиомол хомсдол үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.

7. Шатдаг хийн салбарын аюулгүй ажиллагааны эрх зүйн суурь нөхцөл бүрдэх бөгөөд шатдаг хийн импорт, үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, цэнэглэлт, түгээлт, ашиглалтын аюулгүй ажиллагааны заавал дагаж мөрдөх үндсэн шаардлагыг техникийн зохицуулалтаар тогтооно.
8. Салбарын хууль тогтоомжийн хийдэл, давхардал арилна. Зөвшөөрлийн тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль, Барилгын тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нэр томьёо, суурь зарчмын хувьд бүрэн нийцэж, салбарын хяналт ба удирдлагын нэгдмэл байдал хангагдана.

Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал:

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон Улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Хэмжил зүйн тухай хууль, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан боловсруулна. Мөн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

---o0o---

**ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд хэсэг, заалт нэмэх
2 дугаар зүйл	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн зарим хэсэг, заалтад нэмэлт оруулах
3 дугаар зүйл	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах
4 дүгээр зүйл	Газрын тосны бүтээгдэхүүний тухай тухай хуулийн зарим хэсэг, заалтад өөрчлөлт оруулах

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.11, 4.1.12, 4.1.13, 4.1.14, 4.1.15, 4.1.16 дахь заалт:

“4.1.11. “шатдаг хий” гэж шингэрүүлсэн газрын тосны хий, шахсан болон шингэрүүлсэн байгалийн хийг;”

4.1.12. “газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц” гэж улсын төсөв, бусад эх үүсвэрээр төрийн өмчид бүрдүүлж, хангамжийн тасалдал, хомсдол болон хуульд заасан бусад нөхцөлд ашиглах газрын тосны бүтээгдэхүүнийг;

4.1.13. “газрын тосны бүтээгдэхүүний хэрэглэгчийн нөөц” гэж стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулдаг, энэ хуулийн 5.1.6-д заасан журмын шалгуурт хамаарах эцсийн хэрэглэгчийн өөрийн өмчийн газрын тосны бүтээгдэхүүний заавал байлгах нөөцийг;

4.1.14. “газрын тосны бүтээгдэхүүний чанар” гэж газрын тосны бүтээгдэхүүн нь үндэсний болон олон улсын стандарт, техникийн зохицуулалтад нийцэж байгааг илэрхийлэх физик-хими, ашиглалт, байгаль орчин, аюулгүй байдлын үзүүлэлтийн нийлбэрийг;

4.1.15. “газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт” гэж газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдах бүх үе шатанд түүний чанарын үзүүлэлт нь үндэсний болон олон улсын стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор сорьц авах, шинжлэх, үнэлэх, баталгаажуулах, хянан, шалгах үйл ажиллагааг.

4.1.16. “хангамжийн тасалдал, хомсдол” гэж газрын тосны бүтээгдэхүүний импорт, дотоодын үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалт, түгээлтийн доголдлоос шалтгаалан зах зээлийн хэвийн хэрэгцээг хангах боломж алдагдсан, эсхүл бодит нөөц Засгийн газраас тогтоосон доод түвшинд хүрсэн нөхцөлийг.”

2/ 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалт:

“5.1.6. энэ хуулийн 13.7-д заасан газрын тосны бүтээгдэхүүний хэрэглэгчийн нөөц бүрдүүлэх хуулийн этгээдийг тодорхойлох салбар, хэрэглээ, тасралтгүй ажиллагааны болон эрсдэлийн шалгуур, нөөцийн доод хэмжээ, бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, зарцуулах журмыг батлах.”

3/5 дугаар зүйлийн 5.2.6, 5.2.7, 5.2.8 дахь заалт:

“5.2.6. газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын сорьц авах, хадгалах, тээвэрлэх, шинжлэх, давтан шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг бүртгэх, мэдээлэл солилцох журмыг стандартчилал, хэмжил зүйн болон гаалийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны байгууллага, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

5.2.7.энэ хуулийн 6.3-т заасан нэгдсэн цахим мэдээллийн системд бүртгэх мэдээллийн төрөл, мэдээлэл дамжуулах хэлбэр, давтамж, хадгалах хугацаа, мэдээлэлд нэвтрэх эрх, мэдээллийг ашиглах, хамгаалах, системийн тасралтгүй ажиллагааг хангах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

5.2.8.газрын тосны бүтээгдэхүүний агуулах, шатахуун түгээх станцын сав, түгээгүүрийг автомат түвшин хэмжигч, тоолуур, мэдээлэл дамжуулах төхөөрөмжөөр тоноглох техникийн шаардлага, эрсдэлийн ангилал, хамрах хүрээ болон үе шаттай хэрэгжүүлэх хуваарийг стандартчилал, хэмжил зүйн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах.”

4/5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг:

“5.4.Шатдаг хийн импорт, үйлдвэрлэл, хадгалалт, тээвэрлэлт, цэнэглэлт, түгээлт, ашиглалтын аюулгүй ажиллагааны заавал дагаж мөрдөх үндсэн шаардлагыг техникийн зохицуулалтаар тогтооно. Техникийн зохицуулалтыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу баталж, мөрдүүлнэ.”

5/6 дугаар зүйлийн 6.1.10, 6.1.11, 6.1.12, 6.1.13, 6.1.14, 6.1.15 дахь заалт:

“6.1.10.энэ хуулийн 5.2.6-д заасан журмын төслийг боловсруулах;

6.1.11.энэ хуулийн 6.3-т заасан нэгдсэн цахим мэдээллийн тогтолцоог эрхлэн хөтлөх, мэдээллийн бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангах арга хэмжээг зохион байгуулах;

6.1.12.энэ хуулийн 4.1.3, 4.1.4, 4.1.9-д заасан барилга байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн цогцолборын техник, технологийн шийдэл нь холбогдох техникийн зохицуулалт, норм, дүрэм, стандартын шаардлагад нийцсэн эсэх талаар дүгнэлт гаргах;

6.1.13.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын үе шатанд энэ хуульд заасан чиг үүргийн хүрээнд чанарын хяналтыг хэрэгжүүлэх, эрх бүхий бусад байгууллагатай мэдээлэл солилцох;

6.1.14.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн автомат түвшин хэмжигч, тоолуур, мэдээлэл дамжуулах төхөөрөмж нь техникийн зохицуулалт, хэмжил зүйн шаардлагад нийцсэн эсэхэд болон мэдээлэл дамжуулалтын бүрэн байдалд хяналт тавих;

6.1.15.газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн эрсдэлийг үнэлж, хангамжийн тасалдал, хомсдол үүссэн, эсхүл үүсэх нөхцөл бүрдсэн талаар газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал, дүгнэлт хүргүүлэх.”

6/6 дугаар зүйлийн 6.3, 6.4 дэх хэсэг:

“6.3.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, нөөц, бүтээгдэхүүний хөдөлгөөн, борлуулалт, хангамж болон чанарын мэдээллийг нэгтгэн боловсруулах, хангамжийн эрсдэлийг үнэлэх, шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нэгдсэн цахим мэдээллийн системтэй байна.

Нөөц, орлого, зарлага, савны үлдэгдлийн мэдээллийг бодит цагийн горимоор, чанарын шинжилгээ болон бусад мэдээллийг энэ хуулийн 5.2.7-д заасан хугацаа, давтамжаар бүртгэнэ.”

6.4.Нэгдсэн цахим мэдээллийн системийн эзэмшигч газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь системд хадгалагдах төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээлэл болон кибер аюулгүй байдлын хамгаалалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хангана. Хуулиар нийтэд мэдээлэхээр зааснаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын нууцад хамаарах мэдээллийг зөвхөн хуульд заасан зорилгоор ашиглана.”

7/12 дугаар зүйлийн 12.2.3, 12.2.4, 12.2.5 дахь заалт:

“12.2.3.үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, эрсдэлийн ангилалд тохирсон газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний чиглэлийн инженер, техникийн ажилтантай байх;

12.2.4.энэ хуулийн 5.2.8-д заасан техникийн шаардлага, хамрах хүрээ, үе шаттай хэрэгжүүлэх хуваарийн дагуу өөрийн эзэмшлийн агуулах, шатахуун түгээх станцын сав, түгээгүүрийг баталгаажсан автомат түвшин хэмжигч, тоолуур, мэдээлэл дамжуулах төхөөрөмжөөр тоноглож, энэ хуулийн 6.3-т заасан нэгдсэн цахим мэдээллийн системд мэдээллийг тогтоосон хэлбэр, давтамжаар дамжуулах;

12.2.5.нэгдсэн цахим мэдээллийн тогтолцоонд дамжуулах мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хариуцах, төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, техникийн саатал гарсан тохиолдолд энэ хуулийн 5.2.7-д заасан журмын дагуу мэдээлэх.”

8/13 дугаар зүйлийн 13.4, 13.5, 13.6, 13.7, 13.8, 13.9, 13.10 дахь хэсэг:

“13.4.Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэх, худалдан авах, хадгалах, хамгаалах, даатгах, чанарыг хадгалах, сэлгэн борлуулах, ашиглах, нөхөн бүрдүүлэхтэй холбоотой зардлыг улсын төсөв болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

13.5.Газрын тосны бүтээгдэхүүний импорт, бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компани нь нөөцийг заавал бүрдүүлнэ. Компанийн нөөц нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмч байна.

13.6.Компанийн нөөцийн хэмжээг өмнөх 12 сарын импорт, үйлдвэрлэл, бөөний борлуулалтын дундаж, бүтээгдэхүүний нэр төрөл, зах зээлийн нийлүүлэлт болон хангамжийн эрсдэлийг харгалзан Засгийн газар тогтооно. Шинээр тусгай зөвшөөрөл авсан компанийн нөөцийг тухайн хуулийн этгээдийн бизнес төлөвлөгөө, гэрээт нийлүүлэлт, төлөвлөсөн борлуулалтад үндэслэн тогтооно.

13.7.Стратегийн ач холбогдол бүхий салбарт явуулж буй үйл ажиллагаа нь тасралтгүй байх нь улсын эдийн засаг, нийгмийн хэвийн үйл ажиллагаанд чухал нөлөөтэй, Засгийн газраас тогтоосон хэрэглээний болон эрсдэлийн шалгуурт хамаарах хуулийн этгээд нь хэрэглэгчийн нөөц бүрдүүлнэ.

13.8.Хангамжийн тасалдал, хомсдол үүссэн эсхүл үүсэх бодит эрсдэл бий болсон үед газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн улсын нөөцөөс зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, байршил, нийлүүлэх хугацааг Засгийн газар шийдвэрлэнэ.

13.9.Хангамжийн тасалдал, хомсдлын үед компанийн болон хэрэглэгчийн нөөцийг ашиглах нөхцөл, дараалал, доод үлдэгдэл, нөхөн бүрдүүлэх хугацааг энэ хуулийн 5.1.4-т заасан хариу арга хэмжээний төлөвлөгөө болон энэ хуулийн 5.1.3, 5.1.6-д заасан журмаар тогтооно. Хувийн өмчийн нөөцийг төрөөс зах зээлд нийлүүлэх шийдвэр гаргахтай холбогдуулан үнэ, төлбөр, нөхөн олговор, тооцоо хийх зарчмыг энэ хуулийн 5.1.3, 5.1.6-д заасан журамд тусгайлан зохицуулах бөгөөд энэ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

13.10.Газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн нэр төрөл, хэмжээ, байршил, сэлгэлт, зарцуулалт, нөхөн бүрдүүлэлтийн мэдээллийг энэ хуулийн 6.3-т заасан нэгдсэн цахим мэдээллийн тогтолцоонд бүртгэнэ.

9/15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг:

15.2. Нэгдсэн цахим системийн мэдээллийг хууль бусаар ашигласан, гуравдагч этгээдэд задруулсан, нууцлал, аюулгүй байдлыг алдагдуулсан хүн, хуулийн этгээд, албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

2 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалтын “олгох,” гэсний дараа “сунгах,” гэж, 5.2.4 дахь заалтын “бүтээгдэхүүний” гэсний дараа “импорт,” гэж, 8 дугаар зүйлийн 8.4.1. дэх заалтын “үндэсний стандартад” гэсний өмнө “олон улсын болон” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/1 дүгээр зүйлийн 1.1 дахь хэсэг:

“1.1.Энэ хуулийн зорилт нь газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах, чанар, аюулгүй байдлын хяналт хэрэгжүүлэх, нөөц бүрдүүлэх болон хангамжийн тогтвортой байдлыг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.”

2/2 дугаар зүйл:

“2.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль тогтоомж”

3/2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг:

“2.1.Газрын тосны бүтээгдэхүүний хууль тогтоомж нь Газрын тосны тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Хэмжил зүйн тухай хууль, Барилгын тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Автотээврийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.”

4/4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.4, 4.1.5, 4.1.9, 4.1.10 дахь заалт:

“4.1.1."газрын тосны бүтээгдэхүүн" гэж газрын тос, хийн конденсац болон нүүрс-устөрөгчийн бусад нэгдлүүдийг технологийн гормын дагуу боловсруулж гарган авсан

бүх төрлийн шатахуун, шатдаг хий, тусгай шингэн, тос тосолгооны материал, битум, мазут болон бусад бүтээгдэхүүнийг;

4.1.4."түгээх станц" гэж бүх төрлийн шатахууныг хүлээн авах, хадгалах, бүртгэх, тээврийн хэрэгслийг цэнэглэх, савласан бүтээгдэхүүний жижиглэнгийн худалдаа эрхлэхэд зориулсан техник, технологийн барилга, байгууламж, инженерийн системийн цогцолборыг;

4.1.5."компанийн нөөц" гэж бүх төрлийн шатахуун импортлох, бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуульд заасны дагуу заавал бүрдүүлж, өөрийн өмчид хадгалж байгаа газрын тосны бүтээгдэхүүнийг;

4.1.9."газрын тос боловсруулах үйлдвэр" гэж газрын тос, завсрын бүтээгдэхүүнийг физик, химийн болон бусад технологийн аргаар боловсруулж газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалт бүхий үйлдвэрлэлийн цогц байгууламжийг;

4.1.10."завсрын бүтээгдэхүүн" гэж газрын тосыг боловсруулах технологийн шат дамжлагын явцад гарсан үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, эсхүл дараагийн шатны боловсруулалтад орох нүүрс-устөрөгчийн химийн нэгдлүүдийг."

5/5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5 дахь заалт:

"5.1.2.газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, хадгалах, сэлгэн борлуулах, ашиглах, нөхөн бүрдүүлэх журмыг батлах;

5.1.3.газрын тосны бүтээгдэхүүний импорт, бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн нөөцийн хэмжээ, нэр төрлийг тогтоох, нөөц бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, зарцуулах, нөхөн бүрдүүлэх журмыг батлах;

5.1.4.газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тасалдал, хомсдлын үүссэн болон үүсэж болох эрсдлийг тогтоох, авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлах, нөөц болон түүнийг хадгалах агуулах, шилжүүлэн ачих, тээвэрлэлтийн дэд бүтцийн хүчин чадлыг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан үе шаттай нэмэгдүүлэх;

5.1.5.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, хадгалалт, тээвэрлэлт, худалдааны чанар, аюулгүй байдлын хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авах."

6/7 дугаар зүйлийн 7.1.1 дахь заалт:

"7.1.1.олон улсын болон үндэсний стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох;"

7/8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг:

"8.2.Газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмж нь олон улсын болон үндэсний стандарт, холбогдох техникийн баримт бичгийн шаардлагад нийцсэн байна."

8/8 дугаар зүйлийн 8.3.3 дахь заалт:

"8.3.3.газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын техник, технологийн дүгнэлт;"

9/8 дугаар зүйлийн 8.4.2 дахь заалт:

“8.4.2.газрын тосны бүтээгдэхүүний чанарын шинжилгээ, туршилт хийх итгэмжлэгдсэн лабораторитой байх, эсхүл итгэмжлэгдсэн лабораторитой гэрээ байгуулсан байх;”

10/9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалт:

“9.2.3.газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын техник, технологийн дүгнэлт.”

11/9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалт:

“9.3.2.олон улсын болон үндэсний стандартад нийцсэн газрын тосны бүтээгдэхүүн худалдах;”

12/9 дүгээр зүйлийн 9.5.3 дахь заалт:

“9.5.3.газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын техник, технологийн дүгнэлт.”

13/13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3 дэх хэсэг:

“13.1.Газрын тосны бүтээгдэхүүний нөөц нь улсын, компанийн болон хэрэглэгчийн нөөцөөс бүрдэнэ.

13.2.Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц нь төрийн өмч байх бөгөөд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тасалдал, хомсдол болон хуульд заасан бусад тохиолдолд ашиглана.

13.3.Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүсчилсэн хөгжлийн бодлого, импортын боомт, төмөр зам, авто зам, хүн амын төвлөрөл, хэрэглээний хэмжээ, алслагдсан бүс нутгийн хангамжийн онцлогийг харгалзан төлөвлөж, улсын болон гэрээт хадгалалтын агуулахад байршуулж болно.

4 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтын “дайвар” гэснийг “завсрын” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “нормын” гэснийг “норм, зааврын” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалтын “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 14.1.5-д” гэснийг “Өрсөлдөөний тухай хуулийн 15.1.8-д” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “олон улсын стандартад” гэснийг “олон улсын болон үндэсний стандартад” гэж, 12 дугаар зүйлийн гарчгийн “бүтээгдэхүүний” гэснийг “бүтээгдэхүүнтэй” гэж тус тус өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХЭМЖИЛ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хэмжил зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.13 дахь хэсэг нэмсүгэй:

“10.13. Газрын тосны бүтээгдэхүүн, шатдаг хийн импорт, хадгалалт, түгээлтэд ашиглаж байгаа хэмжих хэрэгсэл, сав, тоолуур, түгээгүүр нь заавал баталгаажуулалтад хамрагдах хэмжих хэрэгслийн ашиглалтын шаардлагыг хангасан байна.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.1.27 дахь заалт нэмсүгэй:

"33.1.27.Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр, агуулах, шатахуун болон шатдаг хийн түгээх станц барьж байгуулах барилга байгууламжийн зураг төсөл болон угсралтын технологид тавигдах тусгай шаардлага, дүрмийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх;"

2 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.27 дахь заалтын дугаарыг "33.1.28" гэж өөрчилсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсоноос хойш, хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн агуулах, шатахуун түгээх станцад автомат түвшин хэмжигч, тоолуур, мэдээлэл дамжуулах төхөөрөмжийг суурьлуулах, нэгдсэн цахим мэдээллийн системд холбох ажлыг Засгийн газар дараах үе шат хуваарийн дагуу авч хэрэгжүүлнэ:

1.1. Нэгдүгээр үе шат: Газрын тосны бүтээгдэхүүний дээш хүчин чадалтай төвлөрсөн агуулах, импортын гол боомт дээрх хадгалах савнуудыг нэгдсэн цахим мэдээллийн тогтолцоонд холбох ажлыг 202... оны ... дугаар сарын ...-ны өдрийн дотор;

1.2. Хоёрдугаар үе шат: Уул уурхай, үйлдвэрлэлийн тусгай зориулалтын агуулах болон нийслэл, аймаг, бүсийн төв дэх авто замын дагуух шатахуун түгээх станцуудыг холбох ажлыг 202... оны ... дугаар сарын ...-ны өдрийн дотор;

1.3. Гуравдугаар үе шат: Бусад сум, баг, алслагдсан бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа шатахуун түгээх станцуудыг холбох ажлыг 202... оны ... дугаар сарын ...-ны өдрийн дотор тус тус бүрэн хэрэгжүүлж дуусгана.

2 дугаар зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд заасан шинээр боловсруулах болон шинэчлэн батлах журам, стандарт, техникийн зохицуулалтыг Засгийн газар энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын дотор батална.

3 дугаар зүйл. Засгийн газар Шатдаг хийн аюулгүй ажиллагааны тухай анхдагч хуулийн төслийг боловсруулж энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 18 сарын дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

